



**АПУ ДЭЙРИ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН 2023 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Улаанбаатар хот, 2023 он**

**БАТЛАВ:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

..... Ц.УРАНЧИМЭГ

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... Г.БАЯРМАГНАЙ

АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
/РЕГИСТРИЙН ДУГААР: 6229654/

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

..... П.ШИНЭЦЭЦЭГ

**БОЛОВСРУУЛСАН:**

АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ХАБЭА-Н ИНЖЕНЕР

..... Т.ӨЛЗИЙЖАРГАЛ

2023 он

## АГУУЛГА

|  |              |
|--|--------------|
| <b>НЭГ. АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>  | <b>4</b>     |
| 1.1 Төслийн товч танилцуулга.....  | 4-5          |
| 1.2 АПУ ДЭЙРИ ХХК-ийн Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга.....  | 6            |
| 1.3 Орчны хяналт шинжилгээ.....  | 7            |
| 1.3.1 Хөрсний бохирдол.....  | 7            |
| 1.3.2 Орчны агаарын чанар.....   | 8            |
| 1.3.3 Усны чанар.....  | 9            |
| <b>ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС<br/>УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....</b>                     | <b>10</b>    |
| 2.1 Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ.....  | 10-11        |
| <b>ГУРАВ. 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>  | <b>12</b>    |
| 3.1 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....   | 13           |
| 3.2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний<br>төлөвлөгөө.....  | 14-15        |
| 3.2.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....  | 16-17        |
| 3.3 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....   | 17-19        |
| 3.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....  | 19-20        |
| <b>ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.....</b>   | <b>21</b>    |
| <b>ТАВ. ХАВСРАЛТУУД.....</b>   | <b>22-42</b> |
| <br>   |              |
| Зураг 1. Үйлдвэрийн байршил.....   | 5            |
| Зураг 2. Үйлдвэрийн зохион байгуулалтын бүдүүвч.....   | 5            |
| Зураг 3. Гадна талбайн ногоон байгууламж, дээжлэлт.....  | 7            |
| Зураг 4. Хөрсний шинжилгээний дээж авч буй байдал.....   | 7            |
| Зураг 5. Гадна орчны агаарын чанарын хэмжилт хийж буй байдал.....  | 8            |
| <br>   |              |
| Хүснэгт:1 Хөрсний сорьц авсан тэмдэглэл.....   | 7            |
| Хүснэгт:2 Хөрсний агрохимийн шинжилгээний хариу.....   | 7            |
| Хүснэгт:3 Хөрсний механик бүрэлдэхүүн.....   | 7            |
| Хүснэгт:4 Гадна орчны агаарын чанарын хэмжилтийн дүн.....  | 8            |
| Хүснэгт:5 Гарч буй хаягдал усны чанарын шинжилгээ.....   | 9            |
| Хүснэгт:6 Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, чиглэл,<br>эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь..... | 10-11        |
| Хүснэгт:7 Компанийн удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....   | 13           |
| Хүснэгт:8 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө хугацаа.....  | 14           |
| Хүснэгт:9 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө.....  | 16           |
| Хүснэгт:10 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....  | 18           |
| Хүснэгт:11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....   | 19-20        |
| Хүснэгт:12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нийт задаргаа.....  | 20           |

**НЭГ. АПУ ДЭЙРИ ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**1.1 Төслийн товч танилцуулга**


|   |  |
|---|--|
| Төслийн нэр:                                | “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр-ЭКО ДЭЙРИ” төсөл   |
| Төсөл хэрэгжүүлэгч:                         | “АПУ ДЭЙРИ” ХХК  |
| Улсын бүртгэлийн дугаар:                    | 9011695053   |
| Регистрийн дугаар:                          | 6229654  |
| Холбоо барих дугаар:                        | 88036838, 99242686   |
| Компанийн үйл ажиллагааны чиглэл:           | <ul style="list-style-type: none"> <li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li> <li>- Жүүс, ундаа үйлдвэрлэл</li> <li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн, жүүсний бөөний болон жижиглэнгийн худалдаа</li> <li>- Гадаад худалдаа</li> </ul>   |
| Төслийн байршил:                            | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо ( шинээр) Номин агуулах худалдааны төвийн урд, Улаанбаатар сувиллын чанх хойно өөрийн эзэмшлийн газар  |
| Төслийн ач холбогдол:                       | Хэрэглэгчдэд эрүүл зөв хоололтод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрлийг байнга нэмэгдүүлж ирснээр дотоодын зах зээлд тэргүүлэгчдийн нэг болтлоо өсөн дэвшиж, импортын бүтээгдэхүүнийг орлох, дотоодын зах зээлийг бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр гарсан Монгол Улсын бодлого, холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж, тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байгаа чухал ач холбогдолтой. |
| Үйлдвэрлэлийн хүчин чадал, тоног төхөөрөмж: | Жилд 45 сая литр сүү үйлдвэрлэх, 150тн бүтээгдэхүүн боловсруулах<br>Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг, Швед улсын Tetrapak, Ecolean Савлах шугам, японы улсын Elopak, EHEDG бүрэн автомат тоног төхөөрөмж   |
| Ажиллах хоног:                              | 365 хоног  |
| Ажиллах хүчин:                              | 42 төрлийн ажлын байранд 313 ажилтантай  |
| Уур, дулаан хангамж:                        | “ДЦС-3” ТӨХК   |
| Цахилгаан хангамж:                          |  |
| Цэвэр усан хангамж:                         | Төвийн шугамд холбогдсон. УСУГ-тай гэрээгээр хамтран ажилладаг.  |
| Хаягдал ус:                                 |  |
| Хөргөлтийн төхөөрөмж:                       | R-404A, R-134a   |
| Аюултай хог хаягдал                         | Химийн аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл бүхий “Түмэн Эгшиг” ХХК-тай гэрээтэй.   |
| Хог хаягдал:                                | Дахивар хог хаягдлыг хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд борлуулах, хадгалах, энгийн хаягдлыг нийслэлийн заасан хогийн цэгт хаях, тээвэрлэх үүрэг хүлээсэн “Эко орчин” ХХК-тай гэрээтэй.   |



Зураг 1. Үйлдвэрийн байршил

**Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт:**

3 блок барилга бүхий оффис, үйлдвэр, лаборатори, түүхий эд, туслах материалын агуулах, аммиак хөргөлтийн цех гэсэн үндсэн хэсгүүдтэй бөгөөд гадна хөргүүртэй контейнер 2ш, харуулын байр, нэрийн барааны дэлгүүртэй.



Зураг 2. Үйлдвэрийн бүтэц, бүрэлдэхүүн

## **1.2 АПУ ДЭЙРИ ХХК-ийн Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга**

АПУ ДЭЙРИ ХХК-ийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь “Тогтвортой хөгжил”-ийн үндсэн суурь зарчим болох НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН тэнцвэртэй хөгжлийг ханган нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэн ажилладаг билээ. Байгаль орчин тогтвортой хөгжлийн стратеги нь АПУ ДЭЙРИ ХХК-ийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бүхий л үйлдвэр үйл ажиллагааны туршид байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажилласаар байна. Иймд 2022 оны тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд “Илүү сайхан дэлхийг цогцлооё” уриан доор үйлдвэрлэл үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийг хэрэгжүүлэн ажиллалаа. 2022 онд байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, хэрэгжүүлэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах, ажлын байрны таатай орчин бүрдүүлэх зэрэг үндсэн зорилтын хүрээнд ажилласан билээ.

### 1.3 Орчны хяналт, шинжилгээ

#### 1.3.1 Хөрсний шинжилгээ

Өмнөх жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 08 сард үйлдвэрийн гадна талбайгаас хөрсний дээжийг авч “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.



Зураг:3 Гадна талбайн ногоон байгууламж, дээжлэлт

Хүснэгт:1 Хөрсний сорьц авсан тэмдэглэл



Зураг:4 Хөрсний шинжилгээний дээж авч буй байдал

|                 |                                 |
|-----------------|---------------------------------|
| Дугаар          | Дээж №1                         |
| Сорьц авсан гүн | 0-20см                          |
| Хөрсний өнгө    | Хархүрэн                        |
| Сорьц авсан цэг | Төв байрны хойд талбайгаас      |
| Солбилцол       | N 47°53'42.5"<br>E 106°53'55.7" |
| Дээж авсан өдөр | 2021.07.08                      |

Хүснэгт:2. Хөрсний химийн шинж чанар

| Дээж авсан цэг | Дээж авсан гүн, см | рН   | Ялзмаг, % | Давс, % | ЦДЧ, dS/m | CaCO <sub>3</sub> , % | NO <sub>3</sub> , мг/л | Солилцох суурь, мг-экв/100гр |                  | Шим тэжээлийн элементүүд, мг/100г |                  |
|----------------|--------------------|------|-----------|---------|-----------|-----------------------|------------------------|------------------------------|------------------|-----------------------------------|------------------|
|                |                    |      |           |         |           |                       |                        | Ca <sup>+2</sup>             | Mg <sup>+2</sup> | P <sub>2</sub> O <sub>5</sub>     | K <sub>2</sub> O |
| Дээж 1         | 0-20см             | 8.11 | 3.29      | 0.152   | 0.419     | 1.92                  | 0.92                   | 6                            | 10               | 3.7                               | 45               |

Хүснэгт:3. Хөрсний механик бүрэлдэхүүн

| Дээж № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм |           |           |            |             |        |       |
|--------|--------------------|---|-----------|-----------|------------|-------------|--------|-------|
|        |                    | 1.0-0.25                                  | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж 1 | 0-20               | 12.9                                      | 64.4      | 8.9       | 2.9        | 6.1         | 4.8    | 13.8  |

Шинжилгээний дүнгээр хөрсний урвалын орчин рН=дунд шүлтлэг, хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт болох ялзмагийн агууламж ихэвтэр, хөрсний солилцох сууриудын нийлбэр Са+Мg баг хангамжтай, ургамалд ашиглагдах тэжээлийн элементүүдийн хангамж дундажаар Нитрат азот (NO<sub>3</sub>) бага, хөдөлгөөнт фосфор (P<sub>2</sub>O<sub>5</sub>) их, солбилцох кали (K<sub>2</sub>O) ихэвтэр хангамжтай, давсжилтгүй, цахилгаан дамжуулах чадваргүй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хархүрэн хөрс байна.

#### 1.3.2 Орчны агаарын чанар

Үйлдвэрийн хашаанд гадна агаарын чанар, физик бохирдол, үйлдвэрийн дотор орчны дуу чимээний үзүүлэлтийг тодорхойлох ажлыг БОХЗТЛ-ийн мэргэжилтэн хийж гүйцэтгэв.



Зураг:5 Гадна орчны агаарын чанарын хэмжилт хийж буй байдал

Хүснэгт:4. Гадна орчны агаарын чанарын хэмжээний дүн

| № | Сорьц авсан цэг                           | Хүхэрлэг хий,<br>SO <sub>2</sub> мг/м <sup>3</sup> | Азотын<br>давхар исэл<br>NO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup> | Нийт тоосны<br>агууламж,<br>мг/м <sup>3</sup> | Дуу чимээ<br>/ДБА/ |
|---|---|--|--|---|--------------------|
| 1 | Үйлдвэрийн хашаан<br>дотор                | 0.012  | 0.027  | 0.128   | 67                 |
|   | Агаарын чанарын стандарт<br>MNS 4585:2016 | 0.450  | 0.200  | 0.500   | 60                 |

Шинжилгээний үр дүнгээс харахад үйлдвэр болон түүний орчмын агаар дахь SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, нийт тоосны агууламж, MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй хэвийн үзүүлэлттэй байна. Харин дуу чимээний үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.9 дахин хэтэрсэн байгаа нь хөргөлтийн моторын дуу их байгаагаас үүдэлтэй.



### 1.3.3 Усны чанар

Төвлөрсөн төвийн шугамын усны дээжинд АПУ ХК-ийн өөрийн итгэмжлэгдсэн төв лабораторит сар бүр чанарын шинжилгээ хийгддэг. Жил бүр МХЕГ-ын хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторит хаягдал уснаас дээж өгч шинжлүүлдэг. Дараах хүснэгтэд сорилтын шинжилгээний тайланг харуулав.

Хүснэгт:5. Гарч буй хаягдал усны чанарын шинжилгээ

| Дээжний дугаар | Шинжилгээний аргын стандарт | Шинжилгээний үзүүлэлтийн нэр    | Шаардлага | Шинжилгээний дүн |
|----------------|-----------------------------|---------------------------------|-----------|------------------|
| 11255          | MNS ISO 5815-1:2015         | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | -         | 221,49мгО/л      |
|                | MNS ISO 6060:2001           | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч    | 800мг/л   | 518,4мгО/л       |
|                | MNS ISO 10523:2001          | pH                              | 6-9       | 10.1             |
|                | MNS ISO 11923:2001          | Умбуур бодис                    | 400мг/л   | 45,0мг/л         |

Сорьцын ерөнхий байдал нь цайвар цагаан саарал өнгөтэй, үнэртэй механик хольц бага тунасан дээд ус булингартай байсан. Усны чанарын шинжилгээний үр дүнгээс харахад бүх үзүүлэлт нь MNS 6561:2015 ариутга татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны стандартад заагдсан зөвшөөрөх дээд агууламжаас хэтэрсэн үзүүлэлтгүй гарсан байна.

**ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

**2.1 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ**

“Цагаан Уулын Оргил” ХХК-иар 2022 онд АПУ ДЭЙРИ ХХК-ийн Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэр-ЭКО ДЭЙРИ төслийн баримт бичиг, зураг төсөл, бүртгэл тэмдэглэл, үйлдвэрийн орчинд хийсэн хэмжилтийн үр дүн, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол доройтлын түвшин, химийн бодисын эрсдлийн үнэлгээ зэрэгт үндэслэн үнэлгээ хийснийг энэ бүлэгт нэгтгэн магадлан жагсаах буюу хяналтын болон асуулгын хуудасны арга математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

Хүснэгт:5 Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, чиглэл, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

|   |   | Хэлбэр |          | Хугацаа             |        |     | Чиглэл         |                    | Эрчим  |      |     |
|---|---|--------|----------|---------------------|--------|-----|----------------|--------------------|--------|------|-----|
|   |   | Шууд   | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино | Урт | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд | Сул |
| <b>1. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны чанарын асуудалд</b> |   |        |          |                     |        |     |                |                    |        |      |     |
| 1.  | Уур амьсгалын өөрчлөлт  |        | -        |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| 2.  | Усны нөөц ашиглалт  | -      |          |                     |        | -   |                | -                  |        | -    |     |
| 3.  | Газрын доорхи усны нөөц хомсдол                                       | -      |          |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| 4.  | Ургамлын нөмрөгт нөлөөлөх   | -      |          |                     |        | х   |                | х                  |        |      | Х   |
| 5.  | Гадаргын усны чанарт нөлөөлөх   |        | -        |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| 6.  | Агаарын чанарт нөлөөлөх   |        | -        |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| 7.  | Хөрсний бохирдол үүсэх  | -      |          |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| 8.  | Химийн бодис хөрсөнд нэвчиж, хөрс ба гүний усыг бохирдуулах           |        | -        |                     | -      |     | -              |                    |        |      | -   |
| 9.  | Эрчим хүч хэрэглэх  | х      |          |                     |        | х   |                | х                  |        |      | Х   |
| 10.   | Дуу чимээ, доргио чичиргээний нөлөө үүсэх                             | -      |          |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| 11.   | Хатуу хог хаягдал үүсэх   | -      |          |                     |        | -   |                | -                  |        | -    |     |
| 12.   | Шингэн хог хаягдал үүсэх  | -      |          |                     |        | -   |                | -                  |        | -    |     |
| 13.   | Химийн бодисын хортой, аюултай хог хаягдал үүсэх                      | -      |          |                     |        | -   |                | -                  |        |      | -   |
| <b>2. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>                           |   |        |          |                     |        |     |                |                    |        |      |     |
| 14.   | Нийгэм, эдийн засагт эерэгээр нөлөөлөх /Бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөх/ | +      |          |                     |        | +   | +              |                    |        | +    |     |
| 15.   | Байгалийн нөөц ашигласны төлбөр, хариуцлага                           | +      |          |                     |        | +   | +              |                    |        | +    |     |
| 16.   | Харьяа орон нутгийн орлого нэмэгдэх                                   | +      |          |                     |        | +   | +              |                    |        | +    |     |

|                          |   |    |    |   |    |    |    |    |   |    |    |
|--------------------------|---|----|----|---|----|----|----|----|---|----|----|
| 17.                      | Харьяа орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх               | +  |    |   |    | +  | +  |    |   | +  |    |
| 18                       | Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөх                       | +  |    |   |    | +  | +  |    |   | +  |    |
| 19                       | Ажлын байр нэмэгдэх                                       | +  |    |   |    | +  | +  |    |   | +  |    |
| <b>3. БУСАД НӨЛӨӨЛӨЛ</b> |   |    |    |   |    |    |    |    |   |    |    |
| 20                       | Үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх |    | -  |   | -  |    | -  |    |   |    | -  |
| 21                       | Хүчтэй салхи, түймэр, аюул осол                           |    | -  |   | -  |    | -  |    |   | -  |    |
| Дүн, тоогоор             |   | 15 | 6  | - | 3  | 18 | 7  | 14 | - | 10 | 11 |
| Дүн, хувиар              |   | 71 | 28 | - | 14 | 85 | 33 | 67 | - | 48 | 52 |

Хүснэгт:6. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

(+) Эерэг нөлөөтэй, (-) Сөрөг нөлөөтэй, (X) Ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй

Нөлөөллийн үр дүн:

Төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт шууд байдлаар үзүүлэх нөлөөллийн 31.2% ямар нэгэн эерэг, сөрөг нөлөөгүй, 18.7% нь эерэг, 50% нь сөрөг нөлөөлөлтэй байна. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад усны нөөц, химийн бодис, бүтээгдэхүүн ашиглах хатуу шингэн хог хаягдал, дуу чимээ доргио чичиргээ үүсэх зэрэг нь сул эрчимтэйгээр урт хугацаанд харин гэнэтийн осол аваар, эрсдэл, гал түймэр, үер, хүчтэй салхи зэрэг нь дунд эрчимтэйгээр богино хугацаанд буцалтгүйгээр шууд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд АПУ групп компани нь жилд ойролцоогоор Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6% буюу 129 тэрбум төг, Онцгой албан татварын орлого 18.3% буюу 95 тэрбум төг, НӨАТ орлог 1.3% буюу 20 тэрбум төг, Гаалийн татварт 3.7 тэрбум төг, ААНОАТ-т 4.8 тэрбум төг, бусад татварь 4.9% тэрбум төгрөгийг дангаараа бүрдүүлдэг тул дунд эрчимтэйгээр урт хугацаанд шууд хэлбэрээр эерэгээр буцаж нөлөөлнө.

Харин орон нутагт физик өөрчлөлт гарах, усны нөөц хомсдох, байгалийн дагалдах нөөц баялаг хомсдох, орчны агаарын чанар зэрэгт ямар нэгэн эерэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

## **ГУРАВ. 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Бид шингэн хүнсний салбарын тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаас байгаль орчны талаар илүү хариуцлагатай бодлого баримтлан хамтдаа харилцан туршлагаа солилцон тогтвортой хөгжихийг уриалан хамтран ажиллаж байна. Бид АПУ групп компанийн хэмжээнд 2022 онд НҮБ – аас баталсан дэлхийн улс орнууд бүх нийтээр дэмжин хүн бүрт хөгжил цэцэглэлтийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэн ажиллана. Бидний зорилго бол эх дэлхийдээ үзүүлэх аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлаж, нийгэм, эдийн засагт оруулах эерэг хувь нэмрийг нэмэгдүүлэх юм. Үүний дотор байгаль орчин тогтвортой хөгжлийн хувьд нөөцийн үр ашигтай менежментэнд тулгуурлан байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхэлж тогтвортой нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах байгаль орчны бодлого доор үйл ажиллагаагаа явуулна. Тайлангийн дараах хэсгүүдээс 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй дэлгэрэнгүй танилцана уу. АПУ ДЭЙРИ ХХК нь 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2022 онд “Цагаан уулын Оргил” ХХК-ийн боловсруулсан АПУ ДЭЙРИ ХХКомпанийн “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн” төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

### **3.1 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө**

АПУ ДЭЙРИ ХХК нь АПУ групп компанийн охин компани бөгөөд Байгаль орчны дэд баг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны (ХАБЭАБО) албанд харьяалагдаж АПУ ДЭЙРИ ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженер нь байгаль орчны ажилтныг хавсран гүйцэтгэдэг ба байгалийн нөөцийн менежмент, түүний зохистой хэрэглээ, хог хаягдлын менежмент, хүрээлэн буй орчинд нөлөөж болзошгүй эрсдлийн менежмент, орчны хяналт шинжилгээ зэрэг чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг ханган ажиллуулах зорилготойгоор ажиллаж байна. Иймд удирдлага зохион байгуулалтын түвшинд дараах ажлуудыг төлөвлөлөө.

Хүснэгт:7 Компанийн удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

| №   | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хүлээгдэх үр дүн  | Хугацаа       | Зардал   | Шаарлага   |
|-----|--|---|---------------|--|--|
| 1.  | БОМТ-ны хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгж бүтцийг шинэчлэн, өргөжүүлэх                                      | БОМТ-ний хэрэгжилтэнд ажилтан бүрийг хамруулж идэвхижүүлнэ.   |               | Цалин урамшууллын хэмжээ                         | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31-р зүйл  |
| 2.  | Хог хаягдлын менежментийн талаарх сургалт зохион байгуулах, хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлэх   | Ажилчдын хог хаягдлын менежментийн талаарх суурь ойлголтыг дээшлүүлэх   | Жилийн туршид | Үйл ажиллагааны дотоод зардлаар                  | Хогны тухай хууль, хог хаягдал ангилан хаях, дотоод журам  |
| 3.  | Хог хаягдлын гэрээ сунгуулах, хамтран ажиллах байгууллагуудыг нэмэгдүүлэх  | Хог хаягдлын гэрээг үргэжлүүлэн сунгасан байна.   | I улиралд     | Гэрээний дүн                                     | Хогны тухай хууль, Аюултай хог хаягдлын тухай хууль  |
| 4.  | Хог хаягдал хуримтлуулах цэгийг стандартын дагуу тохижуулах, ангилан ялгах   | Хог хаягдлын цэг  | III улиралд   | Үйл ажиллагааны дотоод зардлаар                  | Хог хаягдлын тухай хууль   |
| 5.  | Эзэмшил газрын ойр орчмын ногоон байгууламжийг нөхөн сэргээх, мод тарих, ургамалжуулах   | Мод, зүлэг тарих  | II Улиралд    | Үйл ажиллагааны зардал                           | Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах стандарт MNS6260:2011                                 |
| 6.  | Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж гэнэтийн осол эрсдлийн талаар сургалт зохион байгуулах                            | Ажилчдыг гэнэтийн ослын үед цаг алдалгүй арга хэмжээ авах мэдлэгтэй болгох ба гэрээг тогтмол сунгаж ажиллана. | I Улиралд     | Гэрээний дүн                                     | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 4969 : 2000 |
| 7.  | Аюул, эрсдэл өндөртэй ажлын байран дээрх ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулах   | Гэнэтийн ослын даатгал, Тоног төхөөрөмжийн даатгал  | I улирал      | Гэрээний дүн                                     |  |
| 8.  | Ажлын байрны галын аюулгүй байдлыг дүгнэлт гаргуулах   | Дүгнэлтийн хугацаа сунгах   | II улирал     | -  | -  |
| 9.  | Компанийн ойр орчмын гадна талбайд бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах  | Аюулгүй ажлын байр бий болгох   | Тухай бүрт    | Цэвэрлэгээний багаж хэрэгсэл үнийн дүнгийн дагуу | “Эрүүл ахуйн тухай хууль”-ний 4.4.3  |
| 10. | Нийгмийн хариуцлагын хүрээнд: Байгаль орчинд ээлтээ арга хэмжээг төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах                   | Байгаль орчинд холбогдох төслүүдийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ                | Жилийн турш   | Гэрээний дүн                                     |  |
| 11. | Эрчим хүчний менежмент: Дулаан цахилгааны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах | Нэгж үйлдвэрлэлд зарцуулах хэрэглээг бууруулна. (Ус, дулаан, цахилгаан)                                       | Жилийн туршид | Үйл ажиллагааны дотоод сургалтын зардлаар        | -  |
| 12. | Усны нөөцийн менежмент: Усны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах              | Нэгж үйлдвэрлэлд зарцуулах хэрэглээг бууруулна  | Жилийн туршид | Үйл ажиллагааны дотоод сургалтын зардлаар        | -  |

**3.2 Төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээлэлийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилго юм.

Хүснэгт 8. Төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах зардал

| №                               | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд       | Тайлагнах хэлбэр                       | Мэдээллийн агуулга  | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг         | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар  |
|---------------------------------|---|--|---|--------------------------------|-------------------------------|---|---|
| 1.                              | Хорооны иргэдийн төлөөлөл                                   | Тайлагнах, хэлэлцүүлэх                 | Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил   | Жил бүрийн 10 сард             | 1,000,000                     | ХАБЭА инженер                                     | Компанийн байранд   |
| 2.                              | Нийслэлийн байгаль орчны газар                              | Тайлагнах                              | Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан                            | Жил бүрийн 11 сард             | Дотоод үйл ажиллагааны зардал | ХАБЭА инженер                                     | Нийслэлийн байгаль орчны газар  |
| 3.                              | БОАЖЯ Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар | БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах | Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг | Жил бүрийн 12 сар              | Дотоод үйл ажиллагааны зардал | ХАБЭА инженер                                     | БОАЖЯ Eic.mn гео мэдээллийн санд тухайн жилийн биелэлтийн тайлан болон дараа жилийн төлөвлөгөөг оруулах |
| <b>Тодорхойлсон нийт төсөв:</b> |   |  |   |                                | 1,000,000                     |   |   |

### 3.3 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйлдвэрлэл үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлж буй болон болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт:9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| №   | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд  | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж                 | Нийт зардал, сая төг                     | Баримтлах эрх зүйн баримт бичиг  |
|---|---|--|--|--|--|
| <b>Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>           |   |  |  |  |  |
| 1   | Орчны тоосжилт үүсэх, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэж болзошгүй                       | Үйлдвэрийн гадна орчныг тохижуулах, зүлэгжүүлэх, тогтмол цэвэрлэж байх. Дулааны улиралуудад саарал усаар услах, дахин ашиглах цэвэрлэсэн усаар авто зогсоол болон бусад шороон зам талбайг услах | 4-9 саруудад                                   | -  | Газрын тухай хууль, Хөрсний бохирдлын тухай хууль, MNS 5850:2019 (хөрсний чанар, хөрс бохирдуулах бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ)  |
| 2   | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт түгээмэл тархалттай бохирдуулагч бодис (CO, NOx, SO2) ялгарах | Түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлтэнд ашиглах машинг жил бүрийн тогтмол техникийн үзлэг оношилгоонд оруулах, агаар бохирдуулсаны төлбөрийг төлөх                                   | Жилд нэг удаа                                  | 2,0                                      | “Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль”, MNS 4585:2016 (Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага)   |
| <b>Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b> |   |  |  |  |  |
| 3   | Үйлдвэрийн хаягдал ус нь стандартын шаардлага хангасан байх   | Үйлдвэрийн хаягдал усны чанарын шинжилгээ хяналтыг тогтмол хийлгэх. Өөрийн лабораторит сар бүр хийхээс гадна холбогдох итгэмжлэл бүхий лабораториор шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулах         | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан |  | “Усны тухай” хууль (хүрээлэн байгаа орчин усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд тавигдах ерөнхий шаардлага)-MNS 6561:2015 (хүрээлэн буй орчин, усны чанар хаягдал ус) MNS 4943: 2015, ( Хүрээлэн буй |
| 4   | Төслийн хүрээнд усны нөөц ашиглах, хомсдох  | Үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцох, нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг хамгийн боломжит бага хэмжээнд байлгах - Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны           | Жилийн туршид                                  | Сайжруулалтын багуудын нэмэлт урамшуулал |  |

|  |  |  |                 |   |   |
|--|--|--|-----------------|---|---|
|  |  | хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх  |                 |   | орчин, ус ашиглалт, хамгаалалт техникийн шаардлага) MNS 6694:2017   |
| 5  | Ус бохирдуулсны төлбөр төлөх   | Үйлдвэр  | Жилдээ 1 удаа   | 4,5   |   |
| <b>Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b> |  |  |                 |   |   |
| 6  | Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдал ил задгай үүсэх, хаягдлыг зайлуулалгүй удааснаар хөрс бохирдох | Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хатуу хог хаягдал шилжүүлэх устган зайлуулах гэрээ байгуулах, сунган ажиллах - хатуу хог хаягдлыг ангилан ялгах боломжтой шаардлага хангасан хогийн төв цэгийг сайжруулах - хог хаягдлыг тогтмол хугацаанд шилжүүлэх | Жилийн турш     | хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан | Хог хаягдлын тухай хууль, - MNS 5344:2003 - Хог хаягдлыг ангилан ялгаж хаях тухай журам -Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль |
| 7  | Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, зөөгдөх  | Үйлдвэрийн нийт ногоон байгууламж бүхий талбайг тордон арчлах, услах, Машин техникийг тогтоосон зам талбайгаар явуулах   | Жилийн турш     | тодорхойлох боломжгүй                             | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль  |
| 8  | Орчны сөрөг нөлөөллийг бууруулах   | Нийт эзэмшил талбайн 10%-иас доошгүй талбайг зүлэгжүүлэх   | II, III улиралд | 2,0   | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль  |
| <b>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</b>                              |  |  |                 |   |   |
| 9  | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх                                     | “Тэрбум мод” төсөл: Ногоон соёлыг түгээх ажилчдын хашаанд мод тарих төслийн хүрээнд 300 м.кв талбайд мод тарин зүлэгжүүлэх   | 5-9 сар         | 4.0   | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль  |
| 10   |  | “Тунгалаг Туул” төсөл болон бусад олон нийтийн үйл ажиллагаа, аян арга хэмжээнд хамтран ажиллах:   | 6-9 сар         | 2,0   |   |
| <b>Тодорхойлсон нийт төсөв:</b>  |  |  |                 | <b>14,500,000</b>                                 |   |



3.3.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт:10 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

| №                                       | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд              | Хяналтын цэгийн байршил   | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нийт зардал, мянган төг | Тайлбар   | Баримтлах стандарт, арга аргачлал   |
|---|--|---|--------------------|----------------|-------------------------|---|---|
| <b>Агаарын чанарын хяналт шинжилгээ</b> |  |   |                    |                |                         |   |   |
| 1                                       | Агаарын чанар- NO2, SO2, нийт тоосны агууламж  | Нийт-2 цэгт Үйлдвэрийн гадна ба дотор орчин<br>- Үйлдвэрийн урд болон хойд хэсэгт<br>- Агуулахуудын дотор хэсэгт  | Жилд нэг удаа      | 1              | 165,0                   | Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторит шинэчлүүлэх  | MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 2                                       | Дуу чимээ - Дотоод орчны дуу шуугианы түвшин   | Нийт-5 цэгт<br>- Хөргөлтийн цех<br>- Боловсруулахын Б заал- УНТ хэсэг<br>- Бололвсруулахын Б заал- Элопак-6000 хэсэг<br>- ЦИ-ны хатаагч хэсэг<br>- ЦИ-ны өргөтгөл | Жилд нэг удаа      | 1              | 280,0                   | Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторит шинэчлүүлэх  | MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага   |
| <b>Усны чанарын хяналт шинжилгээ</b>    |  |   |                    |                |                         |   |   |
| 3                                       | Төвлөрсөн ус хангамжийн усны чанарын шинжилгээ | Усны шүүлтийн системийн шат дамжлагын ус  | Сар бүр            | 12             | -                       | АПУ ХК-ийн Итгэмжлэгдсэн төв лабораторит шинжлүүлнэ   | MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.  |
| 4                                       | Нийлүүлэх хаягдал усны шинжилгээ               | Ариутгах татуургын шугамд орохын өмнөх хэсгээс эсвэл үйлдвэр тус бүрийн хаягдал ус гаргах хэсгээс   | Улиралд нэг удаа   | 4              | 400,0                   | АПУ төвийн хаягдал усны лабораторит шинжлэнэ. Мөн УСУГ -ын төв лабораторид жилд нэг удаа шинжлүүлнэ | MNS6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усанд тавигдах ерөнхий шаардлага   |

| Хөрсөн бүрхэвчний хяналтын шинжилгээ |  |  |               |   |                  |  |  |
|--------------------------------------|--|--|---------------|---|------------------|--|--|
| 5                                    | Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд | Нийт-3 цэгт<br>1. Аюултай хог хаягдлын цэгийн орчимд<br>2. Дөпдын урд талын ногоон байгууламж<br>3. ББ-ний агуулахын урд талын ногоон байгууламж | Жилд нэг удаа | 1 | 200.0            | Эрдэс судлалын Хан Лаб лабораторид шинжлүүлнэ. | MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд |
| 6                                    | Хөрсний чанар, Хүнд металлууд, Нян судлал        | Нийт-3 цэгт<br>1. Аюултай хог хаягдлын цэгийн орчимд<br>2. Дөпдын урд талын ногоон байгууламж<br>3. ББ-ний агуулахын урд талын ногоон байгууламж | Жилд нэг удаа | 1 | 450.0            |  |  |
| <b>Тодорхойлогдсон үнийн төсөв:</b>  |  |  |               |   | <b>1,495,000</b> |  |  |

### 3.4 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Химийн бодисын хадгалалтад Монгол Улсын хууль, дүрэм журмууд болон компанийн дотоод журам болох химийн бодисын хяналтын тухай журмын дагуу хяналт тавин ажиллаж байна. Компанийн хэмжээнд нийт 74 нэр төрлийн химийн бодисыг төв лаборатори болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглаж байна. Үйлдвэрийн технологи болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглах бодисуудыг “Soruga” олон улсын компанийн бодисыг хэрэглэдэг ба лабораторийн хэрэгцээний химийн бодисуудыг дотоодын компаниудаас худалдан авдаг. Бодисуудын сав, баглаа боодол бүрэн бүтэн эсэхийг шалган тээвэрлэх бөгөөд бодисууд нь хоруу чанар багатай, тогтвортой шинж чанартай. Хадгалалтын хувьд химийн бодисуудыг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. “MNS 6458:2014”- ийн шаардлага хангасан агуулахад хадгалах журмын дагуу ангилан, нэр хаяг, шошго, анхааруулах үг, тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалах тул санамсаргүй осол, эрсдлээс бусад тохиолдолд сөрөг нөлөө бага. Үйлдвэр үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй бүх химийн бодисыг ХАЛМ-тай байлгаж бүртгэлжүүлэн ажиллаж байна. Бодисууд нь 25-200кг болон 20-200л-ийн хэмжээ шуудай, хуванцар савлагаатай.

| №  | Болзошгүй аюул, осол, эрсдэл үүсч, болохуйц үйл ажиллагаа | Болзошгүй аюул, осол эрсдэл  | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ   | Баримтлах стандарт, аргачлал  |  |
|----|---|--|--|---|--|
| 1. | Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх               | Химийн хорт болон аюултай бодис асгарах  | Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах                                  | Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2 дугаар бүлэг   |  |
|    |   | Эрсдлийн болон тээвэрлэлтийн үед авах арга хэмжээг мэдэхгүйн улмаас аюул осол гаргах, эрсдлийн нөлөөллийг ихэсгэх  | Тээвэрлэлт болон химийн бодистой харьцдаг ажилтнуудыг сургалтанд хамруулж, химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох  |   |  |
|    |   | Химийн бодисыг тээвэрлэлт хийх нөхцлийг хангахгүй байх   | Химийн бодисын тээвэрлэхдээ сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хангах, асгарч алдагдсан тохиолдолд хураан авах саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр хангах |   |  |
| 2. | Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах                | Химийн бодисын агуулахын стандарт нөхцлийг хангаагүйн улмаас аюул осол, эрсдэл үүсгэх  | Химийн бодисуудыг битүүмжлэл сайтай хуурай, сэрүүн агааржуулалт сайтай агуулахад бодисын хор аюулын мэдээлэлд заасны дагуу хадгалах  | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, Ерөнхий шаардлага MNS 6458:2014, үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дотоод журам |  |
|    |   |  | Химийн бодисын агуулахыг стандартын дагуу тохижуулах, агуулахын орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх   |   | Химийн бодис асгарч, алдагдах, ажиллагсад хордох, бэртэх, гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бэлэн байх |
|    |   |  | Болзошгүй эрсдэл тохиолдсон үед эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах                                       |   |  |
| 3. | Эрсдэл тохиолдсон үед                                     | Гал гарсан тохиолдолд гал унтраагуур, гал түймрийн голомтод ажиллагсдыг бүх биеийг хамгаалах хувцас, хэрэгсэл, бээлий хорт утааны багтай ажиллах нөхцлөөр хангах               |  |   |  |
|    |   | Химийн бодис асгарсан тохиолдолд химийн бодис хадгалах, зориулалтын саванд цуглуулах, шингээгч материал ашиглах, асгарсан талбайг сайтар цэвэрлэх, агааржуулах                 |  |   |  |
|    |   | Эрсдэлд өртөгч ажиллагсад хүн амын эрүүл мэндийг хамгаалах: Нүд, арьс салст, амьсгал болон залгисан тохиолдолд зааврын дагуу арга хэмжээ авах, эмнэлгийн анхан тусламж үзүүлэх |  |   |  |
|    |   | Ноцтой ослын үед аюулын бүс тогтоох, энэ талаар мэргэжлийн байгууллага (ОБЕГ, МХЕГ)-д нэн даруй мэдэгдэж орчны хяналт  |  |   |  |

|                               |              |  |   |
|-------------------------------|--------------|--|---|
|                               |              | шинжилгээний талаар дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах   | Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль |
|                               |              | Эрсдэлд өртсөн, эвдэрсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэх болон өөрчлөх  |   |
|                               |              | Химийн бодисын байгаль орчны бохирдол, сөрөг нөлөөг бууруулах, арилгах: ХАЛМ-д заагдсаны дагуу бохирдлыг саармагжуулах арга хэмжээ авах, нөлөөллийн хэмжээ их үед холбогдох мэргэжлийн байгууллага ОБЕГ, МХЕГ-т түргэн шуурхай мэдэгдэж арга хэмжээ авах |   |
| <b>Тодорхойлогдсон төсөв:</b> | <b>үнийн</b> |  | <b>2,000,000</b>  |

### 3.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

АПУ ДЭЙРИ ХХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж байна. Үүний хүрээнд хог хаягдлын хэмжээ энэ үеийн өмнөхтэй харьцуулахад 5% -иар бууруулсан байна. Бид хог хаягдаа дахивар болон идэвхгүй хаягдал зэргээр дөрвөн төрөлд ангилж, цааш нь дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч болон дахин боловсруулах компаниудад нийлүүлдэг. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах үйлдвэрт тус тус нийлүүлдэг боллоо. Үйлдвэрлэлээс гарч буй органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолжийн үлдэгдлийг малчдад нийлүүлэн өгч байна. 2023 онд хог хаягдлын 3R менежментийг хэрэгжүүлэн ангилан хаялтыг нэмэгдүүлэн дахивар хаягдлуудыг дахин ашиглаж, дахин боловсруулалтанд шилжүүлэн ландфиллд хаягдах хог хаягдлын хэмжээг бууруулахаар зорин ажиллана.



Хүснэгт: 12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| №  | Хог хаягдлын ангилал          | Ангилалд хамаарах   | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжүүлэх хугацаа | Шилжүүлэх давтамж | Нийт зардал, сая төг       | Баримтлах стандарт аргачлал                                      |
|----|-------------------------------|---|--|---------------------|-------------------|----------------------------|--|
